

АМЕРИКИЙН ЭРДЭМТДИЙН ТАЙВАНИЙ АСУУДЛААРХ ҮЗЭЛ БОДОЛ, БАЙР СУУРЬ

*Н.Отгонсүрэн**

Хятад-Америкийн харилцаа төдийгүй "хоёр эргийн" харилцааны цаашдын хөгжилд Тайваний асуудал чухал нөлөөтэй. АНУ-ын засгийн газраас "Нэг хятад улс" бодлогыг дэмжиж, Тайваний асуудлаар АНУ-ын эрдэмтэд өөр өөрсдийн үзэл бодлыг илэрхийлж дараах утга санаа бүхий хэд хэдэн саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. АНУ-ын Засгийн газар "Нэг хятад улс" бодлогыг үргэлжлүүлэн дэмжиж, БНХАУ-тай сөргөлдөхөөс зайлсхийж байна.

БНХАУ-ын удирдагчид Тайваний асуудал бол Хятадын дотоод асуудал бөгөөд "Хоёр Хятад улс", "Нэг Хятад, нэг Тайвань", "Тайвань тусгаар тогтнох" зэрэг аливаа хувилбарууд аль нь ч байж болшгүй, харин "Нэг Хятад улс" бодлогыг хэрэгжүүлэх замаар хоёр эргийн асуудлыг шийдэх нь зүйтэй гэж үзэж байгаа ажээ.

АНУ-ын ерөнхийлөгч Ж.Буш БНХАУ-аас дэвшүүлж буй энэхүү "Нэг Хятад улс" бодлогыг нааштай хүлээн авч дэмжиж байгаа төдийгүй Тайваний асуудлыг шийдвэрлэхдээ БНХАУ-тай сөргөлдөх биш энхийн замаар буюу яриа хэлэлцээний үндсэн дээр шийдвэрлэхийг тууштай дэмжиж байгаа билээ.

1997 оны 3-р сарын 31 нд америкийн нэртэй хятад судлаач, Америкийн Төрийн нарийн бичгийн дарга асан Киссенжер Германы "Дэлхийн ням гариг" сонинд өгсөн ярилцлагадаа "АНУ-ын засгийн газар "Нэг Хятад улс" бодлогыг дэмжиж байгаагийн зэрэгцээ БНХАУ-тай сөргөлдөхгүй. Америк-Хятадын харилцаанд оршиж буй хамгийн чухал асуудал бол Тайваний асуудал мөн бөгөөд БНХАУ нь АНУ-ын гадаад бодлогод онцгой байр суурь эзэлдэг" гэжээ. Тэрээр энэхүү ярилцлагандаа Тайваний асуудлаар хэд хэдэн санаа хэлсэн байна. Үүнд: 1. "БНХАУ-ын хувьд Тайвань бол "гадаад" улс орон биш харин 1895 онд Японы колони болсон тэр цагаас эхлэн хятадын мэдлийн жижиг арал байсаар ирсэн. 2. Америк-Хятадын харилцаанд улс төрийн хүрээнд таатай бус асуудлууд оршиж байгаа хэдий ч хоёр тал Азид энх тайвныг хөгжүүлэх талаар нийтлэг эрх ашгийг баримталдаг. 1997 онд Хонконг эх газарт эргэж ирсэний дараа АНУ-ын ерөнхийлөгч асан Клинтон "Тайваньтай холбогдсон асуудлаар АНУ-ын баримталдаг гол

* Н.Отгонсүрэн - магистр

бодлогууд хэзээ ч өөрчлөгдөхгүй, Тайваний асуудлыг хүчээр шийдвэрлэж болохгүй” гэж онцлон хэлж байсан. 3. 1997 оны 11-р сард болсон Америк-Хятадын харилцааны зөвлөлийн хурал дээр Америкийн батлан хамгаалах яамны сайд асан Жеймс Шлезингер / James R. Schlesinger / хэлэхдээ: Одоогоор болон ойрын үед Хятад улс, Америкийн цэргийн үйл ажиллагаанд аюул учруулж чадахгүй. Цаашид Хятад улс хүчирхэгжих нь мэдээж, гэвч хэрвээ Америк Хятадтай сөргөлдсөн тохиолдолд л Хятад Америкийг үнэхээр “сөрөг” хүчнээ гэж хандах болно хэмээн тэмдэглэж байсан.

АНУ-ын эрдэмтдийн үзэж байгаагаар богино хугацаанд хоёр эргийн цаашдын хамтын ажиллагааг яриа хэлцэл хийх замаар өргөжүүлэх мөн хоёр эргийн болоод бүс нутгийн тогтвортой байдлыг чухалчилж хоёр талын харилцан итгэлцлийг бэхжүүлэх нь чухал юм. АНУ- БНХАУ-ын харилцаа ойртон сайжрах тусам Тайваньд ашигтай. Учир нь Тайваний асуудлыг энхийн тайван замаар шийдвэрлэх нь Америк-Хятадын харилцааны цаашдын чиг хандлагатай шууд холбоотой.

1982 оны 7-р сарын 14-нд буюу Рейгана засгийн газрын үед Тайваний талаар дэвшүүлж байсан 6 баталгааг Ж.Буш ерөнхийлөгчөөр сонгогдсоны дараа дахин давтан нотолж байсан байна. Үүнд:

1. АНУ-ын засгийн газраас “Тайваньд зэвсэг худалдаалахыг зогсоох” гэсэн БНХАУ-ын саналтай нийлэхгүй,
2. Тайваньд зэвсэг худалдаалахаас өмнө Бээжинтэй хэлэлцээ хийхгүй,
3. Тайбэй-Бээжингийн харилцаанд хөндлөнгөөс оролцохгүй,
4. Тайваний гадаад харилцааны хуулинд засвар оруулахыг зөвшөөрөхгүй,
5. Тайваний бүрэн эрхт байр суурийг өөрчлөхтэй санал нийлэхгүй,
6. Тайбэй-Бээжингийн хооронд яриа хэлцэл хийхэд шахалт үзүүлэхгүй зэрэг болно.

2001 оны 3-р сард БНХАУ-ын дарга Зэн Зэмин Америкийн “Вашингтон” сонинд ярилцлага өгөхдөө “Холбооны улс гэдэг нь хоёр ба түүнээс дээш эрх мэдэл бүхий улсын нэгдэл, харин БНХАУ-ын түүхийн онцлог болон уламжлалт байдал нь холбооны улсад тохирохгүй” гэжээ Энэхүү хэлсэн үгэндээ БНХАУ-ын эрх баригчид хоёр эргийн цаашдын харилцааг холбооны улсын хэв маягтай байхыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа нь “Нэг Хятад улс зарчмын дор ямар ч

асуудлыг шийдвэрлэж болно” гэсэн байр суурийг тууштай баримталж байгаагийн илрэл юм.

Тайваны асуудал нь Америк-Хятадын харилцаанд оршиж буй чухал асуудал төдийгүй хэн ялж, хэн ялагдах нь гол биш эцсийн дүнд Тайвань л ялагч буюу ялагдагч нь болох юм гэж АНУ-ын эрдэмтэд үзэж байна.

2. Америкийн эрдэмтэд Тайваны улс төрийн тогтолцооны хөгжилд өндөр үнэлэлт өгч байна.

АНУ дахь хятад суудлаачид Тайваний асуудлыг анхааран судалж, Тайваний хоолойн аюулгүй байдлаас гадна Тайваний ардчилсан улс төрийн тогтолцооны хөгжлийн явцыг онцгойлон үзэж энэ талаар багагүй бүтээл туурвиж нийтийн хүртээл болгосон байна. Үүний нэг жишээ бол Техникийн их сургуулийн олон улсын харилцааны тэнхимийн профессор Гао Лунцзян Тайваний сонгуулийн явцыг өөрийн биеэр ажигласны дараа Тайваний ардчиллыг үнэлж, мөн түүнчлэн 1996 оны хямрал нь БНХАУ, АНУ, Тайвань тэдгээрийн харилцаа болон Азийн бусад улс орны байдалд үзүүлсэн нөлөө, ач холбогдлын талаар задлан шинжилсэний дүнд “Харьцуулах нь: БНХАУ, АНУ болон Тайваний ардчилал” номыг туурвижээ. Энэхүү ном нь дэлхий нийтийн анхаарлыг татсан БНХАУ, АНУ, Тайваний гурвалсан харилцааг задлан шинжилснээрээ онцлогтой.

АНУ-ын эрдэмтдийн үзэж буйгаар 1. Ардчилсан Тайвань нь Хятад-Америкийн харилцаанд тодорхойгүй буюу тогтворгүй нөхцөлийг бий болгосон. 2. АНУ-ын засгийн газар Тайваний ардчиллыг тууштай дэмжиж, хамгаалдаг төдийгүй Тайваньд ардчилал үүсч бий болсон нь АНУ-ын олон жилийн нөлөө байгаа нь эргэлзээгүй гэж үздэг ажээ.

БНХАУ болон Тайваний хооронд улс төрийн хүрээнд маргаантай асуудлууд гарч ирэх нь мэдээж, хоёр талын удирдагчдын үзэж байгаагаар энэхүү зөрчлийн гол нь: 1. Зэн зэминь “Тайвань, Бээжингийн харьяат” байхыг шаардаж байхад Ли Дэнхуй “хоёр тал тэгш эрхтэй” байхыг тууштай дэмжих. 2. Зэн Зэмин “Тайвань гадаад харилцаа эрхлэх”-ийг зогсоох шаардлага тавьж байхад Ли Дэнхуй Бээжин “Тайваны гадаад харилцааг хөгжүүлэхэд хориг тавихгүй байхыг хүсэх, 3. Зэн Зэмин “Бээжин, Тайваньд цэргийн хүч хэрэглэхийг тууштай баримталж байхад Ли Дэнхуй энэ эрх мэдлээ орхихыг шаардах зэрэг болно.

Бээжин, Тайваньд цэргийн дарамт үзүүлж байгаа нь улс төрийн зорилготой төдийгүй БНХАУ-ын удирдагчдын зүгээс Тайвань болон

Америкт өөр өөр зорилт тавьж байгаа билээ. Үүнд Тайвань юуны түрүүн "Гадаад харилцаа эрхлэхийг" зогсоох төдийгүй "Нэг улс, хоёр систем" бодлогыг хүлээж авах, харин АНУ-ын хувьд БНХАУ-аас Тайваний асуудлаар гаргасан зарчмуудыг АНУ-ын тал гуйвуулахгүй байх, цаашлаад Тайвань БНХАУ-ын салшгүй нэг хэсэг гэдгийг зөвшөөрүүлэхийг хүсч байгаа юм.

АНУ-ын удирдах хүмүүс болоод шинжээчид Бээжин Тайваньд цэргийн хүч хэрэглэх буюу эдийн засгийн хөгжилд нь хохирол учруулж чадахгүй, мөн Тайваньд бий болсон чөлөөт ардчилсан улс төрийн тогтолцоо нь БНХАУ-ын нөлөөнд өртөхгүй байх нь чухал хэмээн үзэж байгаа ажээ.

Тайваний ерөнхийлөгч Чэн Шуйбянь 2001 оны 5-р сард гадаад айлчлалаа эхэлж АНУ-ын Нью-Йорк хотод түр байх үед хүмүүс Ардчилсан дэвшилтэт намын тугийг барин улс төрийн эсэргүүцлийн жагсаал хийж "Чэн Шуйбянь бол Тайваний ерөнхийлөгч биш, ардчилсан дэвшилтэт намын удирдагч мөн" гэж шүүмжлэн дургүйцлээ илэрхийлж байсан байна.

Өнөөгийн байдлаар хуваагдмал улс орны тоонд Хятад, Солонгос зүй ёсоор орж байгаа билээ. Хуваагдмал улс орны эсрэг тэсрэг улс төрийн тогтолцооны харилцаанд цэргийн мөргөлдөөн, улсын хууль ёсны буюу олон улсын хэмжээнд хуулинд нийцсэн өрсөлдөөн, мөн эдийн засгийн хөгжлийн ялгаа гэсэн 3 төрлийн мөргөлдөөн байнга гарч байдаг. Улс орны дотоодын улс төрийн тогтолцоонд оршиж буй эдгээр зөрчлүүд нь дэлхийн II дайны дараа олон улсын улс төрийн хүрээн дэх гол асуудал болсоор ирсэн юм.

Өнгөрсөн хугацаанд Хятадын эх газар ба Тайваний удирдагчид аль засгийн газар нь улс төр, эдийн засгийн салбарт илүү сайн ажиллаж чадах болоод Хятадын хувьсгалт үндэсний үзлийг залгамжлах, Хятад улсыг хэрхэн нэгтгэх, аль нь Хятад улсын хууль ёсны засгийн газар байх вэ зэрэг асуудал дээр санал зөрөлдөөнтэй байсаар ирсэн билээ.

1949-1994 онд Хятадын эх газар ба Тайваний хооронд олон улсын тавцанд бий болсон хууль ёсны шинжтэй сөргөлдөөнийг дараах 3 үе шатанд хувааж болно. 1. 1949-1971 он. Энэ хугацаанд Тайвань АНУ-ын дэмжлэгийг нэлээд авч байсан бөгөөд 1960-аад оны сүүл үеэр Хятадын эх газар 57 улсын дэмжлэг авч байхад Тайвань өөрийгөө 68 улсаар хүлээн зөвшөөрүүлж байсан байна. 2. 1971-1989 он. БНХАУ НҮБ-д гишүүнээр элссэнээр 136 улсаар өөрийгөө хүлээн зөвшөөрүүлж байхад Тайванийг 20 гаруйхан улс хүлээн зөвшөөрчээ. 3. 1989-1994

он. Олон улсын харилцааны өөрчлөлт болоод Тайвань стратегийн зохицуулалт хийснээр Тайваний олон улсын тавцанд эзлэх байр суурь нэмэгдсэн байна.

АНУ-ын эрдэмтдийн үзэж буйгаар хоёр эргийн цаашдын төлөв байдал буюу үр ашигтай стратеги нь улс төр, эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлээ түргэтгэж, цаашлаад хоёр эргийн эдийн засгийн хөгжлийн зөрөөг багасгах явдал юм.

Ашигласан материал

1. Интернет [http: /www.find.articles.com/](http://www.find.articles.com/)
2. Коммунист Хятадын судлал сэтгүүл, Тайбэй 2001